

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/38/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)  
Улаангом хот  
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Аудитор: Ч.Мөнхтогтох  
Утас: 70453721, Цахим хаяг: Munkhtogtokhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

УВС АЙМГИЙН ЭРҮҮЛ  
МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГА  
Ц.АЛИМАА ТАНАА

2023.02.24 № УВА-2023/38/НА-СТА-ТМЗ  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Увс аймгийн Эрүүл мэндийн газар нь 18,981.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг балансаас балансад, үнэ төлбөргүй 1,802,060.6 мянган төгрөгийн бараа материалыг шилжүүлэн авч, 29,950.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө акталж, төсвийн хөрөнгөөр 4,209.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө худалдан бэлтгэсэн байна.

### Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

### Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

0200700571

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Дүгнэлтийн үндэслэл .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	3
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал .....	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	17
4.5.1 Завсрын аудитын талаар .....	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ.....	18

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
ТШЗ	Төсвийн шууд захирагч
НА	Нийцлийн аудит

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>825,339,430.45</b>	<b>561,639,286.16</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>8,679,377.00</b>	<b>0.00</b>
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	3,329,377.00	0.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	5,000,000.00	0.00
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>350,000.00</b>	<b>0.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	350,000.00	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>816,660,053.45</b>	<b>561,639,286.16</b>
<b>35100</b>	<b>Түүхий эд материал</b>	<b>789,800,145.45</b>	<b>543,254,248.95</b>
35110	Тусгай зориулалттай материал	6,121,426.00	550,000.00
35130	Эм боох материал	783,678,719.45	542,704,248.95
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>26,859,908.00</b>	<b>18,385,037.21</b>
35410	Бичиг хэргийн материал	1,810,850.00	922,450.00
35420	Аж ахуйн материал	19,796,418.00	16,239,587.21
35470	Бусад хангамжийн материал	5,252,640.00	1,223,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>684,614,717.85</b>	<b>654,740,727.45</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>684,614,717.85</b>	<b>654,740,727.45</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>655,698,717.85</b>	<b>625,824,727.45</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	535,147,390.53	525,773,562.84
39202	Хуримтлагдсан элэгдэл	-46,062,983.25	-48,918,874.08
39203	Авто-тээврийн хэрэгсэл	245,471,297.00	245,471,297.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-137,457,408.13	-161,082,408.13
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	160,995,971.27	164,566,726.05
39206	Хуримтлагдсан элэгдэл	-112,855,686.02	-107,444,733.59
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	52,909,678.01	43,729,321.01
39208	Хуримтлагдсан элэгдэл	-44,417,801.56	-38,040,223.65
39214	Бусад үндсэн хөрөнгө	9,081,000.00	7,874,000.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-8,832,800.00	-7,824,000.00
39217	Ном	1,720,060.00	1,720,060.00
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>28,916,000.00</b>	<b>28,916,000.00</b>
39301	Програм хангамж	3,215,000.00	635,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3,215,000.00	-635,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	28,916,000.00	28,916,000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>1,509,954,148.30</b>	<b>1,216,380,013.61</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,048,000.00</b>	<b>7,604,237.11</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>7,048,000.00</b>	<b>7,604,237.11</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>7,048,000.00</b>	<b>7,604,237.11</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	7,604,237.11
<b>41360</b>	<b>Бусад өглөг</b>	<b>7,048,000.00</b>	<b>0.00</b>
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	7,048,000.00	0.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>1,502,906,148.30</b>	<b>1,208,775,776.50</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>1,502,906,148.30</b>	<b>1,208,775,776.50</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	819,365,247.44	819,365,247.44
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	819,365,247.44	819,365,247.44
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>592,685,488.75</b>	<b>298,555,116.95</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-104,491,630.14	592,685,488.75
51220	Тайлант үеийн үр дүн	697,177,118.89	-294,130,371.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	90,855,412.11	90,855,412.11
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>1,509,954,148.30</b>	<b>1,216,380,013.61</b>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

			/ төгрөгөөр /
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>10,526,113,123.43</b>	<b>4,867,745,751.20</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>6,130,748,108.43</b>	<b>1,821,035,426.20</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>6,130,748,108.43</b>	<b>1,821,035,426.20</b>
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	42,372,307.55	18,981,346.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	6,088,375,800.88	1,802,054,080.20
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>4,395,365,015.00</b>	<b>3,046,710,325.00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	<b>2,534,240,500.00</b>	<b>2,849,331,800.00</b>
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,534,240,500.00	2,849,331,800.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>1,861,124,515.00</b>	<b>197,378,525.00</b>
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	216,410,415.00	126,626,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,392,264,000.00	52,006,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	252,450,100.00	18,746,025.00
<b>II</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>9,828,936,004.54</b>	<b>5,161,176,122.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>9,828,936,004.54</b>	<b>5,161,176,122.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>6,800,963,122.19</b>	<b>3,107,408,356.99</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>582,834,813.31</b>	<b>531,314,147.22</b>
210101	Үндсэн цалин	349,889,436.00	346,896,093.54
210102	Нэмэгдэл	156,881,833.31	82,731,770.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,022,000.00	38,901,000.00
210104	Урамшуулал	42,041,544.00	62,785,283.68
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>71,782,538.34</b>	<b>77,356,577.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	53,536,238.34	56,244,777.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,561,600.00	5,027,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,649,300.00	4,022,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	912,300.00	1,005,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,123,100.00	11,055,900.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>45,470,646.00</b>	<b>45,763,577.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	4,546,741.00	9,626,990.00
210302	Түлш, халаалт	37,400,000.00	33,020,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,263,905.00	1,836,587.00
210304	Байрны түрээс	260,000.00	1,280,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>327,223,801.00</b>	<b>79,194,932.06</b>
210401	Бичиг хэрэг	14,307,755.00	3,928,800.00
210402	Тээвэр, шатахуун	60,398,551.00	47,826,342.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	5,973,065.00	8,370,858.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	0.00	1,096,200.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	246,544,430.00	17,972,732.06
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>5,382,401,752.59</b>	<b>2,158,458,715.75</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,367,084,252.59	2,147,886,215.75
210502	Хоол, хүнс	1,890,000.00	5,340,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	13,427,500.00	5,232,500.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>117,922,051.20</b>	<b>50,121,879.68</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	95,786,151.20	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	715,000.00
210604	Урсгал засвар	22,135,900.00	49,406,879.68
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>77,174,815.00</b>	<b>52,099,300.00</b>
210702	Дотоод албан томилолт	77,174,815.00	52,099,300.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>12,357,754.00</b>	<b>28,020,742.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,162,000.00	20,640,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,200,000.00	3,200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,154.00	151,142.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,072,000.00
210807	Газрын төлбөр	264,800.00	264,800.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>183,794,950.75</b>	<b>85,078,486.28</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	13,056,000.00	20,490,650.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	121,516,380.00	12,222,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	49,222,570.75	52,365,136.28
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>3,027,972,882.35</b>	<b>2,053,767,765.89</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>3,025,826,800.00</b>	<b>1,741,144,842.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	645,321,298.00	712,831,866.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,082,597,502.00	1,012,712,976.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,297,908,000.00	15,600,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>2,146,082.35</b>	<b>312,622,923.89</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,145,841.00	312,622,923.89
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	241.35	0.00
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>697,177,118.89</b>	<b>-293,430,371.68</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>0.00</b>	<b>700,000.12</b>
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	0.00	700,000.12
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>697,177,118.89</b>	<b>-294,130,371.80</b>

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/ төгрөгөөр /			
Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,395,365,015.00	3,051,710,325.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,395,365,015.00	3,051,710,325.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,534,240,500.00	2,849,331,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,534,240,500.00	2,849,331,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,861,124,515.00	202,378,525.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	216,410,415.00	126,626,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,392,264,000.00	57,006,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	252,450,100.00	18,746,025.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,356,865,115.00	3,047,500,525.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,356,865,115.00	3,047,500,525.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,323,100,232.65	993,732,759.11
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	586,167,190.31	523,709,910.11
210101	Үндсэн цалин	345,757,897.00	339,291,856.43
210102	Нэмэгдэл	156,881,833.31	82,731,770.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	34,022,000.00	38,901,000.00
210104	Урамшуулал	49,505,460.00	62,785,283.68
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	72,129,538.34	73,677,200.00
210201	Тэтгэврийн даатгал	53,883,238.34	52,565,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,561,600.00	5,027,900.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,649,300.00	4,022,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	912,300.00	1,005,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	9,123,100.00	11,055,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,470,646.00	45,763,577.00
210301	Гэрэл, цахилгаан	4,546,741.00	4,556,402.00
210302	Түлш, халаалт	37,400,000.00	37,695,000.00
210303	Цэвэр, бохир ус	3,263,905.00	2,232,175.00
210304	Байрны түрээс	260,000.00	1,280,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	96,605,209.00	73,267,030.00

210401	Бичиг хэрэг	5,320,055.00	4,499,550.00
210402	Тээвэр, шатахуун	62,254,571.00	47,827,242.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,069,765.00	8,734,958.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,100,000.00	700,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	18,860,818.00	11,505,280.00
2105	Нормативт зардал	250,552,570.00	111,962,800.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	237,052,570.00	105,062,800.00
210502	Хоол, хүнс	2,800,000.00	5,750,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	10,700,000.00	1,150,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	41,129,200.00	49,332,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,420,000.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,800,000.00	2,660,600.00
210604	Урсгал засвар	33,909,200.00	46,672,200.00
2107	Томилолт, зочны зардал	70,126,815.00	59,147,300.00
210702	Дотоод албан томилолт	70,126,815.00	59,147,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	13,257,754.00	27,778,742.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,062,000.00	20,640,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00
210803	Даатгалын үйлчилгээ	3,200,000.00	3,200,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	60,154.00	151,142.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	66,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	2,830,000.00
210807	Газрын төлбөр	264,800.00	264,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	147,661,310.00	29,093,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	25,339,000.00	20,199,900.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	122,322,310.00	8,893,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,033,764,882.35	2,053,767,765.89
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,026,618,800.00	1,741,144,842.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	645,321,298.00	712,831,866.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,082,597,502.00	1,012,712,976.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,298,700,000.00	15,600,000.00

2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	7,146,082.35	312,622,923.89
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,145,841.00	312,622,923.89
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	5,000,241.35	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	38,499,900.00	4,209,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	38,499,900.00	4,209,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	38,499,900.00	4,209,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	38,499,900.00	4,209,800.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	38,499,900.00	4,209,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-38,499,900.00	-4,209,800.00

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	/ төгрөгөөр /
				Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	819,365,247.44	91,521,243.01	-105,157,461.04	805,729,029.41
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	665,830.90	665,830.90
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	819,365,247.44	91,521,243.01	-104,491,630.14	806,394,860.31
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	-665,830.90	0.00	-665,830.90
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	697,177,118.89	697,177,118.89
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	819,365,247.44	90,855,412.11	592,685,488.75	1,502,906,148.30
2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	819,365,247.44	90,855,412.11	592,685,488.75	1,502,906,148.30
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00	0.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	819,365,247.44	90,855,412.11	592,685,488.75	1,502,906,148.30
Өмчид гарсан өөрчилөлт	0.00	0.00	0.00	0.00
Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00	0.00
Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-294,130,371.80	-294,130,371.80
2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	819,365,247.44	90,855,412.11	298,555,116.95	1,208,775,776.50

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	/төгрөгөөр/	
				Гүйцэтгэл зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,849,331,800.00	2,536,708,876.11	312,622,923.89	89.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,849,331,800.00	2,536,708,876.11	312,622,923.89	89.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	812,088,000.00	801,864,034.11	10,223,965.89	98.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	532,594,100.00	523,709,910.11	8,884,189.89	98.3
210101	Үндсэн цалин	327,702,600.00	339,291,856.43	-11,589,256.43	103.5
210102	Нэмэгдэл	118,188,600.00	82,731,770.00	35,456,830.00	70.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,425,000.00	38,901,000.00	1,524,000.00	96.2
210104	Урамшуулал	46,277,900.00	62,785,283.68	-16,507,383.68	135.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	73,677,200.00	73,677,200.00	0.00	100.0
210201	Тэтгэврийн даатгал	52,565,400.00	52,565,400.00	0.00	100.0
210202	Тэтгэмжийн даатгал	5,027,900.00	5,027,900.00	0.00	100.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,022,400.00	4,022,400.00	0.00	100.0
210204	Ажилгүйдлийн даатгал	1,005,600.00	1,005,600.00	0.00	100.0
210205	Эрүүл мэндийн даатгал	11,055,900.00	11,055,900.00	0.00	100.0
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	45,092,200.00	44,188,577.00	903,623.00	98.0
210301	Гэрэл, цахилгаан	4,874,800.00	4,556,402.00	318,398.00	93.5
210302	Түлш, халаалт	36,091,000.00	37,400,000.00	-1,309,000.00	103.6
210303	Цэвэр, бохир ус	4,126,400.00	2,232,175.00	1,894,225.00	54.1
2104	Хангамж, бараа материалын зардал	54,056,600.00	54,051,005.00	5,595.00	100.0
210401	Бичиг хэрэг	5,615,100.00	3,845,550.00	1,769,550.00	68.5
210402	Тээвэр, шатахуун	28,079,200.00	32,564,317.00	-4,485,117.00	116.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,338,500.00	6,465,858.00	2,872,642.00	69.2
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	2,002,000.00	700,000.00	1,302,000.00	35.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	9,021,800.00	10,475,280.00	-1,453,480.00	116.1
2105	Нормативт зардал	8,193,600.00	8,184,800.00	8,800.00	99.9
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	7,035,600.00	7,034,800.00	800.00	100.0

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,158,000.00	1,150,000.00	8,000.00	99.3
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	35,225,200.00	35,212,600.00	12,600.00	100.0
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,213,700.00	4,209,800.00	3,900.00	99.9
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	2,669,300.00	2,660,600.00	8,700.00	99.7
210604	Урсгал засвар	28,342,200.00	28,342,200.00	0.00	100.0
2107	Томилолт, зочны зардал	13,821,300.00	13,821,300.00	0.00	100.0
210702	Дотоод албан томилолт	13,821,300.00	13,821,300.00	0.00	100.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,110,600.00	27,778,742.00	331,858.00	98.8
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	20,641,000.00	20,640,000.00	1,000.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	604,800.00	604,800.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	3,200,000.00	3,200,000.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	430,000.00	151,142.00	278,858.00	35.1
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	110,000.00	88,000.00	22,000.00	80.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	2,860,000.00	2,830,000.00	30,000.00	99.0
210807	Газрын төлбөр	264,800.00	264,800.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	21,317,200.00	21,239,900.00	77,300.00	99.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	20,200,500.00	20,199,900.00	600.00	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,116,700.00	1,040,000.00	76,700.00	93.1
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,037,243,800.00	1,734,844,842.00	302,398,958.00	85.2
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,037,243,800.00	1,734,844,842.00	302,398,958.00	85.2
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	846,535,500.00	712,831,866.00	133,703,634.00	84.2
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,181,408,300.00	1,012,712,976.00	168,695,324.00	85.7
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	9,300,000.00	9,300,000.00	0.00	100.0

III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,849,331,800.00	2,849,331,800.00	0.00	100.0
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,849,331,800.00	2,849,331,800.00	0.00	100.0
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,849,331,800.00	2,849,331,800.00	0.00	100.0

## 2.6 Аудит хийсэн нэмэлтийн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		202,378,525.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ		202,378,525.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		196,078,525.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		1,575,000.00
210302	Түлш, халаалт		295,000.00
210304	Байрны түрээс		1,280,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал		19,216,025.00
210401	Бичиг хэрэг		654,000.00
210402	Тээвэр, шатахуун		15,262,925.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		2,269,100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,030,000.00
2105	Нормативт зардал		103,778,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл		98,028,000.00
210502	Хоол, хүнс		5,750,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		18,330,000.00
210604	Урсгал засвар		18,330,000.00
2107	Томилолт, зочны зардал		45,326,000.00
210702	Дотоод албан томилолт		45,326,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		7,853,500.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		7,853,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		6,300,000.00
2132	Бусад урсгал шилжүүлэг		6,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		6,300,000.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		202,378,525.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		202,378,525.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		126,626,100.00

131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	57,006,400.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	18,746,025.00

### 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

#### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын эрхэм хүн амын эрүүл мэндийг хамгаалах, эрүүл дадал хэвшилтэй, идэвхтэй амьдралын хэв маягтай иргэнийг төлөвшүүлэн, эрүүл мэндийн тусламж үйлчилгээг чанартай хүртээмжтэй хүргэж, үр дүнтэй тогтолцоог хөгжүүлэхэд төр, иргэн аж ахуйн нэгжүүдийн хамтын ажиллагаа хүчин чармайлтыг өрнүүлж монгол хүнийг эрүүл урт наслалтад хүргэх зорилт тавин ажиллаж байна.

#### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар Эрүүл мэндийн тухай хууль, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, төсвийн тухай хууль, бусад хууль, тогтоомжуудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль - 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.
- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ. Тайлант онд дотоод аудит хийгдээгүй байна.

#### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн бөгөөд байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэлээ.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн аливаа бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 293,574.1 мянган төгрөгөөр буурсан байна.

#### Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Авлага	8,679.3	0.0	-8,679.3
Бараа материал	816,660.0	561,639.2	-255,020.8
Үндсэн хөрөнгө	684,614.7	654,740.7	-29,874.0
<b>Нийт хөрөнгө</b>	<b>1,509,954.1</b>	<b>1,216,380.0</b>	<b>-293,574.1</b>
Өр төлбөр	7,048.0	0.0	-7,048.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	1,502,906.1	1,216,380.0	-286,526.1
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>1,509,954.1</b>	<b>1,216,380.0</b>	<b>-293,574.1</b>

Авлага дансны үлдэгдэл 8,679.3 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Эрүүл мэндийн сайдын Сайдын А/802 тоот тушаалаар нэмэлт санхүүжилтийн дансанд оны эцэст орж ирсэн 5,000.0 мянга, нийгмийн даатгалын шимтгэлийн 350.0 мянга, хувь хүний орлогын албан татварын 3,329.4 мянга төгрөгийн авлагыг барагдуулсан байна.

Бараа материал 561,639.2 мянган төгрөг болж 255,020.8 мянган төгрөгөөр буурсан эм боох материалыг сумдад шилжүүлсэнтэй холбоотой байна.

Өр төлбөр 7,048.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас сургалт сурталчилгааг тайлант оны өмнө хийж санхүүжилт нь тайлант онд орж ирсэнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 654,740.7 мянган төгрөг болж 29,874.0 мянган төгрөгөөр буурсан байна. Энэ нь аймгийн ИТХ-ын 2022 оны 8/05 дугаар тогтоолоор үндсэн хөрөнгө актлах шийдвэр гарч данснаас хөрөнгө хассантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,216,380.0 мянган төгрөг болж 286,526.1 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,789.7 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналыг 62.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж 2,852.3 сая төгрөгөөр баталсан байна. Энэ нь Төсвийн төсөл өгсний дараа Засгийн газрын тогоол гарч цалин нэмэгдсэнтэй холбоотой байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,849,331.8 мянган төгрөгийн улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,849,331.8 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 2,536,708.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,536,708.8 мянган төгрөг буюу 89.0 хувьтай байгаа нь үндсэн дансны хэмнэгдэл байна. Үндсэн данснаас 312,622.9 мянган төгрөг төвлөрүүлсэн байна.

#### Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	/мянган төгрөгөөр/	
				Зөрүү	Биелэлт
1	Үндсэн үйл ажиллагаа зардал	798,338.0	788,144.1	10,223.8	98.7
2	Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж	2,037,243.8	1,734,844.8	302,398.9	85.1
3	Хөтөлбөр төслийн дотоод урсгал зардал	13,750.0	13,749.9	0.1	99.9

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын нэмэлт санхүүжилтийн дансаар 202,378.5 мянган төгрөгийн орлого орж 202,378.5 мянган төгрөгийн зарлага гарсан байна. Эрүүл мэндийн яамнаас 57,006.4 мянган төгрөг, ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 126,626.1 мянган төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 18,746.0 мянган төгрөг, нийт 202,378.5 мянган төгрөгийн орлого орсныг зарцуулалтын эрх нээлгэн зориулалтын дагуу зарцуулсан байна.

Үүнээс хангамж бараа материалын зардалд 19,216.0 мянга, байр ашиглалтын зардалд 1,575.0 мянга, норматив зардалд 103,778.0 мянга, эд хогшил худалдан авах зардалд 18,330.0 мянга, томилолт зочны зардалд 45,326.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагналд 6,300.0 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардалд 7,853.5 мянга, нийт 202,378.5 мянган төгрөг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар

сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ч.Мөнхтогтох гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Увс аймгийн Эрүүл мэндийн газар нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 35 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 9,832,265.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 5,139,369.0 мянган төгрөгийн 0.5 хувь буюу 25,696.8 мянган төгрөгөөс 80 хувиар тооцож 20,557.4 мянган төгрөгөөр тогтоолоо.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын хувьд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх заалт “Энэ хуулийн 3.1-д заасан этгээдэд дараах зориулалтаар зардал санхүүжүүлэх, зарцуулахыг хориглоно”, 12.1.4 дэх заалтад “Хуулиар зөвшөөрөөгүй бусад” гэж заасныг зөрчин биеийн тамирын бэлтгэлийн хувцасны зардлыг төсвөөс гаргасан байна.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа байршуулсан 149 мэдээлэл, байршуулах хугацаа болоогүй 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Увс аймгийн Эрүүл мэндийн газар нь Татварын ерөнхий хуулийн 28 дугаар зүйлийн 28.5 дахь хэсэгт “Татвар төлөгч борлуулалт хийх тухай бүрд хэрэглэгчийн системээс дахин давтагдашгүй дугаар бүхий төлбөрийн баримтыг хэвлэж өгөх, эсхүл цахимаар илгээх үүрэгтэй” гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын хувьд дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 880.0 мянган төгрөгийн 10 ширхэг биеийн тамирын өмсгөл худалдан авч төрд хохирол учруулсанд төлбөрийн акт тогтоосон байна.

#### 5.1 Төлбөрийн акт

Увс аймгийн Эрүүл мэндийн газрын нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас 880.0 мянган төгрөгийн 10 ширхэг биеийн тамирын өмсгөл худалдан авч төсвийг үр ашиггүй зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, арвилан хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалтад “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”, Төрийн албаны тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэгт “Төрийн албан хаагч хуульд зааснаас гадна дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно”, 39.1.2 дахь заалтад “Албаны эрх мэдлээ хэтрүүлэх”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.4-д “Энэ тогтоол батлагдахаас өмнө Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу зарлагдсанаас бусад автомашин, албан конторын тавилга, албаны болон ажлын дүрэмт хувцас, амралт, алжаал тайлах, фитнесийн тоног төхөөрөмж, хэрэглэлийн худалдан авалтыг зохион байгуулахгүй байх”, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “Цэргийн алба хаагч, прокурор, гадаадын иргэний хяналтын улсын байцаагч, гаалийн улсын байцаагчаас бусад албан хаагч төсвийн болон байгууллагын хөрөнгөөр дүрэмт хувцас худалдан авахыг хориглоно” гэж тус тус заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байсанд төлүүлэхээр төлбөрийн акт тогтоолоо.

### 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил	/мянган төгрөгөөр/ Үүнээс				
		Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж	Хариуцлага тооцуулах албан шаардлага	Хууль, хяналтын байгууллага д

											шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Төсвөөс Биеийн тамирын бэлтгэлийн хувцасны зардал гаргасан	1	880.0	1	880.0								
Дүн	1	880.0	1	880.0								

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР  Ч.МӨНХТОГТОХ/

2023 оны 02 дугаар сарын 25-ны өдөр